

НОГООН УУЛЫН БИЧЭЭС

Б. Азаяа^{1,*}, Т. Идэрхангай², Б.Амгаланбат³

Товч агуулга: Монгол нутгаас руни бичгийн шинэ шинэ дурсгал жил бүр илэрсээр эдүгээ сүүлийн тоо баримтаар нийт 108 газраас 193 дурсгал бүртгэгджээ. Үүнээс зөвхөн 2023 онд гэхэд таван шинэ дурсгал илэрсэн нь бичээс судлалын хувьд маш чухал амжилт юм. Уг өгүүлэлд, 2022 онд бүртгэгдсэн Ногоон уулын I бичээсийн уншлага судалгаа болон 2023 онд илэрсэн Ногоон уулын II ба III бичээсийн талаар авч үзэх болно. Доктор Т.Идэрхангайгийн удирдсан судалгааны баг 2022 онд Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын зааг нутаг Ногоон уулаас эртний түрэг бичгийн нэгэн дурсгал илрүүлсэн бөгөөд түүний мэдээллийн дагуу 2023 онд тус дурсгалыг судлах явцдаа манай төслийн багийнхан тус газраас мөн хоёр шинэ дурсгал илрүүлсэн болно. Тус судалгааг МУИС-ийн Дэд профессорын судалгаа болон “P2022-4373: Өмнөд болон зүүн бүс нутаг дахь руни бичгийн судалгаа” төслийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Түлхүүр үг: Руни бичиг, Ногоон уул, Монгол улс

Удиртгал

Хэнтий аймгийн Дархан сум, Бор-Өндөр сумын зааг нутагт орших Ногоон уулыг нутгийн зон олон эртнээс тахиж шүтдэг байсан уламжлалтай ажээ. (Зураг 1)

Эртний шүтээнт Ногоон уулын оройн хаданд олон тамга болон хадны сийлмэл, зураасан зураг, руни бичиг байх бөгөөд тэдгээрийг дэд профессор, доктор Т.Идэрхангайн удирдсан хээрийн шинжилгээний ангийн судалгааны ажлын хүрээнд илрүүлжээ (Идэрхангай нар 2022: 309–323).

Судалгааны тайланд “Дархан, Бор-Өндөр сумын нутагт орших Бор-Өндөр сумын төвөөс зүүн хойд зүгт 24 км орчим зайд жижиг аараг толгойдын дунд орой дээрээ жижиг овоотой хадтай толгойг нутгийн зон олон Ногоон толгой хэмээн нэрлэдэг байна. Ногоон толгойн ойр орчим нь чулуун зэвсэг, хадны зураг, булш оршуулгын дурсгалтай. Ногоон толгойн баруун, зүүн урд талд тамга тэмдэг, ан амьтны дүрсэлсэн хадны зураг нийт 41 хадан дээр бий” (Идэрхангай нар 2022: 309) хэмээн газар нутаг, түүхэн дурсгалын талаар тодорхойлон бичжээ.

Ногоон уулын бичээсийг илрүүлсэн багийн мэдээллээр, 2023 оны 5-р сард МУИС-ийн Ази судлалын тэнхмийн дэд профессор, доктор Б.Азаяа удирдан, түрэг судлалын салбарын 3-р ангийн оюутан Б.Бархассүрэн, Ж.Түмэндэмбэрэл, Б.Мөнхцэцэг болон бичээсийг анх илрүүлсэн багийн гишүүн,

Соёлын өвийн үндэсний төвийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын шинжээч Б.Амгаланбат нарын хамт үзэж судалсан билээ. Хаврын салхитай, цаг агаарын тийм ч таатай бус нөхцөлд судалсан учраас бодитой үр дүнд хүрээгүй билээ. Тиймээс дахин 7-р сард мөн тус тэнхимийн багш Б.Азаяа, Т.Загарпэрэнлэй болон профессор, доктор Ц.Баттулга нарын бүрэлдэхүүнтэй судалгааны баг Ногоон уулын бичээсийг үзэж судаллаа.

Энэхүү судалгааны гол зорилго нь өмнөх судалгааг улам гүнзгийрүүлэх, дахин шалгахад оршиж байсан бөгөөд бидний баг шинээр дахин хоёр хэсэг руни бичээс буйг олж илрүүлж амжилттай ажилласан юм. Түүнчлэн нутгийн ардаас газрын нэрийг тодруулахад “Ногоон толгой” бус, “Ногоон уул” хэмээж байсан тул уг судалгааны ажилдаа “Ногоон уул” хэмээх нэрээр оруулах нь зохистой гэж үзлээ.

Эртний хад, чулууны бичээсийг судлахад цаг агаар маш чухал бөгөөд ялангуяа бүдгэрч балархайшсан бичээсийг нэг удаагийн судалгаагаар бүрэн тогтоох боломжгүй байдаг билээ. Тиймээс ч Ногоон уулын бичээсийг хоёр удаа хүрч ахин дахин үзэж судалсны үр дүнд уншиж тайлсан судалгаагаа толилуулж байна.

Ногоон ууланд нийтдээ гурван хэсэг бичээс байх ажээ. Судлаачдын анх олж илрүүлсэн бичээсийг нэгдүгээр бичээс, харин шинээр илрүүлсэн бичээсийг хоёр, гуравдугаар бичээс хэмээн нэрлэв.

Нэгдүгээр бичээс

Т.Идэрхангай нарын судалгааны тайланд, Хадны зураг-01, Хадны зураг-02 хэмээн дугаарлаж “...үл мэдэгдэх дүрслэл...” (Идэрхангай нар 2022: 310) хэмээн тодорхойлсон хоёр дурсгал бол угтаа хэдэн

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Ази судлалын тэнхим
E-Mail: azzaya@num.edu.mn, azzayab2000@gmail.com
<https://orcid.org/0000-0002-6278-6251>

² МУИС, Шинжлэх Ухаан, Технологийн “Улаанбаатар” парк

³ Соёлын Өвийн Үндэсний Төв

иргэдийг нэгтгээд, хураагаад гэсэн утгатай байжээ гэж өмнө дурдсан сонгодог бичгийн дурсгалын загварт тулгуурлан сэргээх боломжтой.

Өөрөөр хэлбэл, 𐰽𐰺𐰍 [ᠳᠤᠳ] bodun tārip āgip—... [-ын] ард иргэдийг нэгтгээд буцаад гэж нэгэн овог аймгийг дайлж нэгтгээд буцсан тухай тэмдэглэжээ.

𐰽𐰺𐰍 уага гэх энэхүү үг Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан багийн нутагт орших Донгойн ширээний гэрэлт хөшөөний бичээст дурдагдаж байна.

Донгойн ширээн цогцолборт нийтдээ 14 гэрэлт хөшөөний 48 хугархай илрүүлсэн бөгөөд II хөшөөний хоёрдугаар хугархайн эхний хэсэгт (W2a) ušga: [yaqa]: ušga: [yaqa]: ab: yaqa: yīšqa: yоq: etmiš: yerim e: yaqa: er: erttirtim e: - Ушга [Зах], Ушга Зах, авын нуруунаа (Авын нуруунаа) хойлгожээ. Нутаг минь ээ! Захын цэрэг засууллаа би ээ! (W3a) ...yaqa uluᠢqa ... -Зах Улуг уруу ... (Баттулга 2022: 23–24; Мөнхтулга 2018: 41–71; Мөнхтулга нар 2014a; 2014b; Мөнхтулга, Оосава 2015) гэж тэмдэглэгдсэн байна.

Үүнээс үзэхэд Түрэгийн үед 𐰽𐰺𐰍 уага гэх үг зах хязгаар, хол алс буюу зах нутаг, зэлүүд нутаг, ан авын нутаг гэсэн утгатай байсан бололтой.

Доктор Р.Мөнхтулга “Үсэгзүй, хэлзүйн онцлог, тамгын хэлбэр, хашлагын чулуун хавтангийн дүрслэл зэрэгт үндэслэн Донгойн Ширээн дурсгалыг 735-745 оны үед Эртний Түрэгийн хожуу хаант улсын, хааны дараа орох ихэс язгууртанд зориулан байгуулсан гэж таамаглаж байна. Донгойн Ширээн дурсгал нь VIII зууны эхэн хагасын Түрэг улсын зүүн жигүүрийн улс төрийн бүлгүүд (“аймаг”, “овгууд”), Хятан, Табаи, Татар зэрэг монгол хэлтэн байсан гэгддэг аймгууд, ялангуяа Монголын дорнод нутгаар нутаглаж асан Татарын түүхийг судлах чухал баримт болохоор байна” (Мөнхтулга 2018: 70) хэмээн дүгнэсэн байна.

Ногоон ууланд руни бичээсээс гадна Донгойн ширээн цогцолборын гэрэлт хөшөөнөө дүрслэгдсэн тамга болон Түрэг, Уйгурын үеийн олон тамгыг хаданд сийлжээ. Эдгээр тамга нь тухайн дурсгалын он цагийн баримжаа тогтооход чухал баримт болдог.

Донгойн ширээн цогцолборын гэрэлт хөшөөний тамга, бичээст тэмдэглэгдсэн 𐰽𐰺𐰍 уага гэх үгээр баримжаалбал Ногоон уулын энэхүү бичээс он цагийн хувьд Донгойн Ширээн дурсгалтай нэгэн үеийн буюу 735-745 онд холбогдох дурсгал байж болох юм.

𐰽𐰺𐰍 qalīṇ- үлдэгтүн гэдэг үгийн эхний хэсэг байхгүй учраас сэргээх боломжгүйг өмнө дурдсан билээ. Хэрвээ бичээсийн хоёрдугаар мөрийг үргэлжлүүлэн бичих боломжгүй байсанд уг хавтгай хадны баруун доор үргэлжлүүлэн ганц 𐰽𐰺𐰍 qalīṇ гэх ганц үг сийлжээ гэж үзвэл 𐰽𐰺𐰍𐰽𐰺𐰍𐰽𐰺𐰍 [ᠳᠤᠳ] bodun tārip āgip уага qalīṇ – ... [-ын] ард иргэдийг нэгтгэж, эргэж захад (зах хязгаарт) үлдэгтүн гэсэн утгатай байж болох юм. Тэр овог аймгийг эзлэн

нэгтгээд, эргэж буцаж зах хязгаарын нутагтаа үлдэгтүн гэж цэрэглэн аян дайнд явагсдад тушаал зарлиг буулгасныг Ногоон уулын оройд цэргүүдэд сонордуулж, улмаар зарлигийг хаданд бичиж үлдээсэн байжээ хэмээн үзвэл тэрхүү аян дайнд явах цэргийн анги нэгтгэлийн бүрэлдэхүүнд байх цэргийн дарга нар өөр өөрсдийн овгийн тамгаа сийлүүлж үлдээсэн байж болох юм.

Өөрөөр хэлбэл, Цэргийн анги нэгтгэл цугларч аян дайнд мордохын өмнө Ногоон ууланд туг сүлдээ мандуулж ёс төр, зан үйл гүйцэтгээд дээрх зарлигийн бичгийг бичиж үлдээсэн бололтой.

𐰽𐰺𐰍𐰽𐰺𐰍 bitidim ā бичив би ээ! гэх энэ бичлэг, аялга илтгэсэн найруулгаараа Донгойн ширээн цогцолборын yerim e- Нутаг минь ээ! гэсэн хэлбэртэй мөн л ижил байгаа нь анхаарал татаж байна.

Хоёрдугаар бичээс

Ногоон уулын хоёрдугаар бичээсийг манай төслийн багийн гишүүн Т.Загарпэрэнлэй анх илрүүлж, мэдээлсэн билээ (Загарпэрэнлэй 2023). Харин уншлага судалгаа нь хараахан хэвлэгдээгүй байна.

Ногоон уулын баруун энгэрт, нэгэн ургаа хадан дээр сул байх тэвэрт багтам шаргал чулуун дээр хоёрдугаар бичээс хэмээн бидний нэрлэж буй бичээсийг бичсэн байна (Зураг 3). Бичээс бичсэн чулуу хагарсан, хугарч унасан шинж байхгүй байгалийн хэлбэр тогтцоороо байх ажээ. Тиймээс хагарч унаснаас бичээсийн тал хэсэг үлджээ гэж үзэх боломжгүй ажээ.

Нэг бичээсийг, ялангуяа бага бичгийн дурсгалын үсэг тэмдэгт тодорхой бус, харагдах байдал балархайдуу бичээсийг судлаач бүр өөр өөрийн нүдээр, өөр өөрийн өнцгөөс харах учраас бүрэн санал нэгдэхэд зарим талаараа боломжгүй зүйл байдаг. Түүний нэгэн адилаар бид уг бичээсийн уншлагын хувилбараа танилцуулж байна.

Бичээсийн эхийн сийрүүлэг:

1ᠳᠰ .1
h×1ᠳ .2

Үсгийн галиг: 1. nčYp
2. Ysdt

Үгийн галиг:
1. anča ayīp
2. ay āsit[t]i

Орчуулга:
1. Тийн хэлж
2. ярь (өгүүл) (тэдэнд) сонсго

Хоёр мөрөөс бүтэх дээрх бичээсийн агуулгаас үзэхэд, элч, цэргийн хүний үгийг тийн хэлж, сонсгоорой гэсэн утга агуулгатай байж болохоор байна. Бид хожим уг бичээсийн талаар дэлгэрэнгүй өгүүлнэ. Энэ удаад бид зөвхөн мэдээлэх зорилгоор дурдсан болохоо тэмдэглэе.

Гуравдугаар бичээс

Ногоон уулын өмнө этгээдэд, ургаа бор хүрэн хад дээр нэг мөр бичээс байх боловч он цагийн уртад балархайшсан учраас тодорхой сайн харагдахгүй болжээ (Зураг 4). Бид дахин судалж, нягталсны хойно энэ бичээсийн талаар тухайлан өгүүлэх болно. Т.Идэрхангай нарын баг уг бичээсийг тайландаа хараахан тусгаагүй боловч зүүн доод буланд байх адуун туурайн хоёр тамгыг бүртгэсэн байна (Идэрхангай et al. 2022: 322).

Ногоон уулаас 2022 болон 2023 онд илэрсэн руни бичгийн энэхүү гурван дурсгал нь тухайн бүс нутагт бичээс болон археологийн өргөн хүрээт судалгааны ажил хийх шаардлагатайг илтгэж байна.

Abstract

INSCRIPTION AT NOGOON UUL

by Badam Azzaya, Tumor-Ochir Iderkhangai and Batdelger Amgalanbat

Every year, in Mongolia, new runic inscriptions are discovered, and according to the latest data, a total of 193 monuments from 108 places have been documented. Only in 2023 were five new inscriptions found, which is a significant accomplishment for epigraphic research. This article will provide information on the II and III inscriptions found in 2023 as well as the first reading interpretations of the Nogoön Uul I inscription found in 2022. Located on the borders of Bor-Öndör and Darkhan soum in Khentii province, Nogoön Uul is site to a monument written in the old Turkic alphabet that was discovered in 2022 by a research team led by Assoc. Prof. Dr. Iderkhangai Tömör-Ochir. Based on the information provided by this team, during the examination of the inscription in 2023, two new inscriptions that had not been previously reported from this area were discovered by our project team.

Acknowledgement: The research has received funding from the National University of Mongolia under grant agreement P2022-4373 and PROF. 2023-2737.

Keywords: Runic inscriptions, Nogoön Mountain, Mongolia

Ном зүй

Баттулга, Ц. (2022). Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: Vol. III: Монголын зүүн, өмнөд бүс нутаг дахь руни бичгийн дурсгал.

Загарпэрэнлэй, Т. (2023, 09.26). Ногоон уулын II бичээсийн тухай. Орхон бичгийн дурсгал - Нүүдэлчдийн хэл, иргэншлийн түүхэн сурвалж болох нь.

Идэрхангай, Т., Оргилбаяр, С., Амгаланбат, Б., Батчимэг, Б., Баянсан, Б., Хүслэн, Л., Намсрайжамц, А., Уянга, Х., Мөнхжин, М. (2022). Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн нутагт явуулсан “Чулууун соёлын өв” төслийн судалгааны ажлын 2022 оны тайлан (Хэвлэмэл тайлан 2-р дэвтэр). Улаанбаатарын Их Сургууль, Түүх, археологийн тэнхим.

Мөнхтулга, Р. (2018). Түрэг, монгол судлалын өгүүллүүд, Эрдэм шинжилгээний бүтээлийн түүвэр (2003- 2018 он).

Мөнхтулга, Р., Болорбат, Ц., Энхтөр, А., Буянхишиг, Ц. (2014а). Донгойн ширээг малтан судалсан нь. Мөнхтулга Р., Болорбат Ц., Энхтөр А., Буянхишиг Ц. (2014б). Донгойн ширээн дурсгал.

Мөнхтулга, Р., Оосава, Т. (2015). Донгойн ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан нь. 21–55.





Зураг 1. Ногоон уул



Зураг 2. Ногоон уулын I бичээс



Зураг 3. Ногоон уулын II бичээс



Зураг 4. Ногоон уулын III бичээс